



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 77

Арвайхээр

Г Аймгийн хөтөлбөр батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 19.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.


ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн
97 дугаар тогтоолын хавсралт

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн хүн амын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 115684, нийт хүн амын 30.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 65.4 хувийг 15-64 насныхан, 4.4 хувийг 65 түүнээс дээш насныхан эзэлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн насны 55.1 мянган хүн ажил эрхэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 47.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажиллагсадыг эдийн засгийн салбарын ангилалаар харвал нийт ажиллагсдын 50.3 хувь нь хөдөө аж ахуй, 14.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 5.4 хувь нь боловсрол, 4.6 хувь нь тээвэр, холбоо, 4.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, 3.7 хувь нь уул уурхай, олборлолт, 3.4 хувь нь боловсруулах үйлдвэр, 3.5 хувь нь барилга, 2.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 2.1 хувь нь зочид буудал, зоогийн газар, 1.7 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч, 3.1 хувь нь бусад салбарт ажиллагсад байна.

Эндээс харахад хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт хөдөлмөр шингээлт их байгаа бөгөөд эдгээр салбарт, тодруулбал хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын 54,5 хувь, бөөний жижиглэн худалдааны салбарт ажиллагсадын 64,6 хувь, зочид буудал, нийтийн хоол үйлчилгээний салбарт ажиллагсадын 79,5, хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Бас нэг тоон үзүүлэлтийг дурьдвал, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 17746 байгаа ба үүний 57,9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд 3117 эмэгтэй гэрийн ажилтай, гэртээ хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асардаг гэсэн тоо байна. Мөн аймгийн хэмжээнд 3400 гаруй өрх толгойлсон эмэгтэйчүүд ажиллаж амьдарч байгаагийн 39.8 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн төлөв байдалтай холбогдол бүхий анхаарал татахуйц дээрх үзүүлэлтүүдээс гадна Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгасан зарим зүйлүүд нь дээрх тоон үзүүлэлттэй холбоотой дүгнэлтийг баталгаажуулж байна. Тодруулбал тус баримт бичигт Өвөрхангай аймгийн зах зээлийн потенциалыг нэмэгдүүлэх гол хүч нь худалдаа. Худалдаа руу чиглүүлэх бизнес нь хөдөө аж ахуй, аялал жуулчлал, барилга, тээвэр логистик гэж дүгнэсэн байна.

Мөн энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтийн нэг нь нийгмийн дэд бүтцийн хангамжийн үзүүлэлтүүд, бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамж, бүтээж байгаа үнэ цэнэ (ДНБ) зэрэг үзүүлэлтүүд гэж тусгажээ. Иймд эмэгтэйчүүд олноор ажиллаж буй албан бус салбар түүний дотор худалдаа, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой, зохистой байлгах бодлогыг хэрэгжүүлэх шаардлага байна гэдэг нь харагдаж байна.

Нөгөө талаар нийгэм дэх ялгарал, давхраажил үүсэхийн нэг шалтгаан, хэмжигдэхүүн нь баялаг, орлоготой холбоотой байдаг. Энэ ч утгаараа дундаж буюу түүнээс доош орлоготой иргэд, гэрийн ажилтай эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг авч үзэх шаардлага байна гэж үзэж энэхүү хөтөлбөрийг боловсруулж байгаа болно.

Хоёр. Хөтөлбөрийн хугацаа, хамрах хүрээ

2.1 Хөтөлбөрийг 2019-2024 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

2.2 Энэхүү хөтөлбөрт малчин, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч, гэрийн ажилтай эмэгтэйчүүдийг хамруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж, хөдөлмөрийн таатай нөхцөлийг бүрдүүлэх, түншлэлд суурилсан бүтээмжтэй, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар тэдний амьдралын чанарыг сайжруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

3.2 Энэхүү хөтөлбөрийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

3.2.1. Эмэгтэйчүүдийг чадавхижуулахад чиглэсэн мэдээлэл, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар эмэгтэйчүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Эмэгтэйчүүдэд олгох санхүүгийн дэмжлэгийн олон талт хэлбэрийг бий болгох замаар тэдний ажлын байраа өргөжүүлэх, ажлын байраа хадгалахад нь дэмжлэг үзүүлнэ.

3.2.3. Эмэгтэйчүүдийн үйлдвэрлэсэн болон худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүнийг борлуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж бүтээмжит хөдөлмөр эрхлэлтийг бий болгоно.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

4.1.1. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэл, чадавх боломжид тулгуурлан сайн дурын үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх

4.1.2. Өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдийн шинэлэг санааг дэмжих

4.1.3. Баг, бүлэг, хамтын хөдөлмөр эрхлэх хэлбэрийг хөгжүүлэх

4.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах

4.1.5. Хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх үйлчилгээ нь зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Эмэгтэйчүүдийг чадавхижуулахад чиглэсэн мэдээлэл, сургалт, нөлөөллийг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар эмэгтэйчүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэсэн нэг дэх зорилтын хүрээнд

5.1.1. Эмэгтэйчүүдийн бизнесийн санааг хөгжүүлэх, бизнесийн үйл ажиллагааг нь бойжуулах, техник технологийн талаарх мэдээлэл хүргэх, бизнесийн зөвлөгөө өгөх “Бизнес мэдээлэл, бизнес инкубацийн төв” байгуулах

5.1.2. Эмэгтэйчүүдийн үйлдвэрчний эвлэл, холбоо, нийгэмлэг, хөдөлгөөн зэрэг бие даасан гишүүнчлэлийн эрх бүхий байгууллагуудыг түншлэлийн зарчмаар дэмжиж ажиллах

5.1.3. Малчин эмэгтэйчүүдийг малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх чиглэлээр мэргэжил олгох сургалтанд үе шаттайгаар хамруулах

5.1.4. Гэрийн ажилтай эмэгтэйчүүдэд өрхийн эдийн засагтаа үр өгөөжтэй хувь нэмэр оруулахад нь чиглэсэн юмханаар юм хийх чадвар чадамж эзэмшүүлэх сургалтуудыг олон талт хэлбэрээр зохион байгуулах

5.1.5. Орлогын хомсдолтой амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн ур

чадвар олгох сургалтанд үе шаттайгаар хамруулах замаар тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох

5.1.6. Хэрэглэгчдийн сэтгэлгээ, хандлагыг өөрчлөн дотоодын бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах

5.1.7. Эмэгтэйчүүдийг өөртөө итгэх итгэл, амьдралын зөв дадал хэвшил, эерэг хандлага төлөвшүүлэх цогц арга хэмжээнд үе шаттайгаар хамруулж чадваржуулах

5.2 Эмэгтэйчүүдэд олгох санхүүгийн дэмжлэгийн олон талт хэлбэрийг бий болгох замаар тэдний ажлын байраа өргөжүүлэх, ажлын байраа хадгалахад нь дэмжлэг үзүүлнэ гэсэн хоёр дахь зорилтын хүрээнд

5.2.1. “Хуримтлалын бүлэг”, “Дундын сан” зэрэг санхүүгийн нөөц бүрдүүлэх боломж, арга замын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.2.2. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, өрх толгойлсон эмэгтэйчүүд, гэрийн ажилтай эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд түлхүү хамруулах

5.2.3. Бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөжүүлэх хүсэлтэй эмэгтэйчүүдийг бага хүүтэй, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд түлхүү хамруулах

5.2.4. Өөрөө өөртөө ажлын байр бий болгож буй жижиглэнгийн худалдаа эрхлэгч, улирлын чанартай ажил эрхлэгч зэрэг бага орлоготой хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих

5.2.5. Удаан хугацаагаар ажлын байр түрээслэн ажиллаж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх ажлыг ажил олгогч эзэд, нийгмийн түншлэлийн байгууллагуудын оролцоо дэмжлэгтэйгээр зохион байгуулах

5.3. Эмэгтэйчүүдийн үйлдвэрлэсэн болон худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүнийг борлуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж бүтээмжит хөдөлмөр эрхлэлтийг бий болгоно гэсэн гурав дахь зорилтын хүрээнд:

5.3.1. Өөрийн ур чадварт түшиглэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй эмэгтэйчүүдийн бараа бүтээгдэхүүнийг “Борлуулалтын цэг”-ээр дамжуулан сурталчилах, худалдаалахад нь дэмжлэг үзүүлнэ.

5.3.2. Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах

5.3.3. Сүү цагаан идээ боловсруулах, үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд өртгийн сүлжээг хөгжүүлэх ажлыг эхлүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.3.4. Хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөрийн бүтээмжийн судалгаа хийж түүнийг мэдээлэх замаар зах зээлийн багтаамжаа судлахад нь дэмжлэг үзүүлэх

5.3.5. Зах зээлд илүүдэлтэй байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний /оёдол, үсчин, талх нарийн боов г.м/ салбарын үйл ажиллагааг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан шинэлэг хэлбэрээр хөгжүүлэх

5.3.6. E-арилжаа, E-үйлчилгээг хөгжүүлэх замаар борлуулалтын сүлжээ бий болгоход нь дэмжлэг үзүүлэх мэдээлэл технологийн чадавхи бэхжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах

5.3.7. Амжилттай сайн ажиллаж буй эмэгтэйчүүдийг алдаршуулах, тэдний хийсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилахад чиглэсэн теле нэвтрүүлэг бүхий видео сан бий болгож олон нийтэд сурталчилах

5.3.8. Өөрийн хийсэн бүтээгдэхүүнээр гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцогч эмэгтэйчүүдийг боломжит бүхий л хэлбэрээр дэмжих

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн төсвийг жил бүрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангах, хөтөлбөрийн явц, үр дүнд дүн шинжилгээ хийж, тайлагнах, олон нийтэд сурталчлах ажлыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцна.

6.3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг анхан шатанд хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангах ажлыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

6.4. Хөтөлбөрийн хүрээнд түншлэгч тал нь төрийн байгууллагууд, хөтөлбөрт хамрагдах эмэгтэйчүүд, ажил олгогч эзэд, мэргэжлийн болон сайн дурын холбоод, олон улсын байгууллагууд байна.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.1.1. Орон нутгийн төсөв

7.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

7.1.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө

7.1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө

7.1.5. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгө

7.1.6. Төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив, тусламж

7.1.7. Хандивлагч, олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт

7.1.8. Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт үнэлгээ хийх

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд 1 удаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тайлагнаж үр дүнг тооцно.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1. Хөтөлбөрт хамрагдсан эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн 10-аас доошгүй хувь нь тогтмол орлоготой болсон байна.

9.2. Албан бус хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд зохион байгуулалтад орж, хамтын хөдөлмөр эрхлэх арга барилд суралцаж албан хэлбэрт шилжих нөхцөл бүрдсэн байна.

9.3. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдан үйл ажиллагаа нь өргөжсөн байна.

9.4. Эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл нэмэгдэн, хөдөлмөр эрхлэх зөв дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж, амьдрал ахуйгаа бие даан авч явах чадвар эзэмшсэн байна.

9.5. Бараа бүтээгдэхүүнийг борлуулах борлуулалтын 3-аас доошгүй сүлжээ бий болж, бүтээгдэхүүний эрэлт ихсэж, нийлүүлэлт өссөн байна.